



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Дотоод аудитын төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны Дотоод аудитын төлөвлөгөөг баталсугай.

2. Дотоод аудитын төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 1 дүгээр улиралд багтаан Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж, тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Өнөрнасан)-т даалгасугай.

САЙД



Г.ДАМДИННЯМ

БАТЛАВ.
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Г.ДАМДИННЯМ



ДОТООД АУДИТЫН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар хот

ТАНИЛЦУУЛГА

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгж нь Монгол Улсын төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын харьяа байгууллагуудад бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэд дотоод аудитыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, арилгуулах, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг.

Дотоод аудитын үйл ажиллагаа нь төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт, шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, замаар тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино. Мөн ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт, шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах зарчим баримтална.

Дотоод аудитын албан хаагчид нь үйл ажиллагаандаа хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Олон Улсын Дотоод аудиторчуудын институтээс гаргасан санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн болон дотоод аудитын ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын дэргэдэх Дотоод аудитын нэгж нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлаа тайлагнан, үйл ажиллагааны стандарт, арга зүйн дэмжлэг авч ажиллана.

Энэхүү аудитын жилийн төлөвлөгөөг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын дэргэдэх Дотоод аудитын нэгжээс хийж гүйцэтгэсэн эрсдэлийн үнэлгээ, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээ, өмнөх жилийн аудитын дүн, тайлан зэрэгт үндэслэн боловсруулсан.

Аудитаар 2026 онд хийгдэх ажлуудыг Дотоод аудитын нэгжид бодитойгоор ашиглах хүний нөөцийн чадавхад үндэслэн тодорхойлсон бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох чиглэлээр яамны албан хаагчдыг татан оролцуулж болно.

Сайдын шийдвэрээр тусгайлан дотоод аудит хийх болон өргөдөл гомдлын мөрөөр хяналт шалгалт хийж гүйцэтгэх бол тэдгээрийг жилийн төлөвлөгөөнд нэмж тусгаж болно.

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ЗОРИЛГЫГ ХАНГАХАД ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад байгууллагын үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд

-сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, төрийн өмчит хуулийн этгээд, байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгө, орлого зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, шилэн дансны хөтлөлтөд дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, тайлагнах;

-улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд дотоод аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах. Түүнчлэн байгууллагын гүйцэтгэлийн

төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны чиглэлийн дагуу 2026 онд хэрэгжүүлэх дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажлыг төлөвлөсөн болно.

ХОЁР. ХИЙГДЭХ АУДИТЫН АЖЛУУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

Аудитын зорилго:

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, заавар журмын хэрэгжилтэд Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу дотоод аудитыг хийх, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Аудитын төрөл:

- ❖ Төсөл арга хэмжээний үр дүнгийн үнэлгээ;
- ❖ Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ;
- ❖ Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх;

2026 онд дараах аудитын ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Аудитын ажил	Хамрагдах нэгж	Аудитын цар хүрээ	Хугацаа
1. ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР			
AA2026/1.1	Эрчис ойл ХХК	Байгууллагын 2025 үйл ажиллагаанд дотоод аудит хийх	I улирал
AA2026/1.2	Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ	Зөвлөмжийн хэрэгжилтэд дотоод аудит хийх	I улирал
AA2026/1.3	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Байгууллагын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	II улирал
AA2026/1.4	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох үйл ажиллагаа	III улирал

AA2026/1.5	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны хуулийн 2026 оны хэрэгжилт	IV улирал
2. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР			
AA2026/2.1	Эрчис ойл ХХК	Байгууллагын 2024, 2025 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	I улирал
AA2026/2.2	Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ	Зөвлөмжийн хэрэгжилтэд дотоод аудит хийх	I улирал
AA2026/2.3	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Байгууллагын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	II улирал
3. БУСАД ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР			
AA2026/3.1	Шаардлагатай тохиолдолд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус аудитыг гүйцэтгэх	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хамрах хүрээг тодорхойлон аудитыг хийж гүйцэтгэх	Тухай бүр

ГУРАВ. АУДИТЫН АЖИЛД ХҮНИЙ НӨӨЦИЙН ХУВААРИЛАЛТ

Аудитын ажилд зарцуулах хугацааны хуваарь болон нэгжийн албан хаагчдыг дараах байдлаар хуваарилав.

Аудитын ажил	Аудитын цар хүрээ	Эрсдэлийн зэрэг	Хугацаа	Хүн-өдөр
1. ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР				
AA2026/1.1	Эрчис ойл ХХК-ийн 2025 үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Их	I улирал	75
AA2026/1.2	Геологийн судалгаа шинжилгээний төв ХХК-д өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд дотоод аудит хийх	Их	I улирал	78
AA2026/1.3	Байгууллагын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Их	II улирал	30
AA2026/1.4	Салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох үйл ажиллагаа	Их	III улирал	125

AA2026/1.5	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны хуулийн 2026 оны хэрэгжилт	Дунд	IV улирал	22
2. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР				
AA2026/2.1	Эрчис ойл ХХК-ийн 2025 үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Их	I улирал	50
AA2026/2.2	Геологийн судалгаа шинжилгээний төв ХХК-д өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд дотоод аудит хийх	Их	I улирал	42
AA2026/2.3	Байгууллагын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Их	II улирал	30
3. БУСАД ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР				
AA2026/3.1	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хамрах хүрээг тодорхойлон аудитыг хийж гүйцэтгэх	-	Тухай бүр	38
Дотоод нэгжийн үйл ажиллагаанд зарцуулах нийт хүн өдөр				<u>490</u>